

“САНХҮҮГ БИХААНЫ
АУДИТ” ХХК

УС, ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР

Аудитын тайлан

Нэмэлтмэдээлэл авахыг хүсвэл
доорх хаягаар харилцана уу:

Захирал Б.Шатар
Утас: 89383852
Цахим хаяг: baldandorj shatar @yahoo.com

Гэрээт аудитор Д.Оюунбат
Утас: 89585807
Цахим хаяг: oyuna200702t@yahoo.com

Хаяг:
Дундговь аймаг Сайнцагаан сум 7 дугаар
баг

АГУУЛГА

ХУУДАС

- Агуулга
- Аудитын гэрчилгээ
- Менежментийн захидал
- Аудит хийсэн санхүүгийн тайлан
- Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	Error! Bookmark not defined.
2	Аудитын тайлан.....	2
2.1	Оршил.....	2
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	2
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	3
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	3
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	4
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	4
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	5
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	6
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	6
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал.....	
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал .	
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.12	Шилэн дансны мэдээлэл	9
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал	10
3.1	<u>«management_zurchil1»</u>	
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	Error! Bookmark not defined.
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	Error! Bookmark not defined.
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	Error! Bookmark not defined.
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	Error! Bookmark not defined.
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	Error! Bookmark not defined.

1 Аудитын тайлан

1.1 Оршил

Говьсүмбэр аймгийн “Ус, цаг уур, орчны шинжилгээний газар”-ын төсвийн захирагч Э.Энх-Одод танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Говьсүмбэр аймгийн “Ус, цаг уур, орчны шинжилгээний газар”-ын 2017 оны санхүүгийн тайланг баталгаажуулах аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Говьсүмбэр аймгийн “Ус, цаг уур, орчны шинжилгээний газар”-ын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго юм.

Төсвийн захирагч нь санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго юм.

Уг газар нь 2017 оны санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 06 дугаар албан бичгээр хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

Аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 02 дугаар сарын 06-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 02 дугаар сарын 07-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, гэрээт аудитор Д.Оюунбат хариуцаж хэрэгжүүлэв.

1.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж–Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000-1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

1.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Говьсүмбэр аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний газар “Анхан шатны ашиглалтын чанарыг сайжруулж ус, цаг уур, орчны чанартай мэдээллээр нийгмийн хэрэгцээг хангах” эрхэм зорилгын дор Цаг уур, орчны шинжилгээний газрын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэж байна.

Уг газар нь тайлант хугацаанд “Сахилга хариуцлагыг дээшлүүлж, ур чадварыг нэмэгдүүлнэ” гэсэн зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Тус байгууллагын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Говьсүмбэр аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараахь хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

1.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

БОАЖС-ын 2009 оны 365 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгосон байна.

Говьсүмбэр аймгийн “Ус, цаг уур, орчны шинжилгээний газар”-ын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Уг газар нь санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох” ХХК-ийн “Acolous” программ хангамж ашиглаж байна.

Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлж шинэчлэлт хийгдээгүйгээс программ дахь дансны төлөвлөгөө зөрүүтэй байна.

1.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Говьсүмбэр аймгийн “Ус, цаг уур, орчны шинжилгээний газар”-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулья.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн тодорхойлсон уламжлалт болон хяналтын эрсдэлийн дагуу горим хэрэгжүүлэн тэдгээрийг ТАБ-СТА-АБ.1- АБ.8 маягтуудаар баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 5 асуудал эрсдэл өндөр гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд зайлшгүй шалгах эрсдэлтэй 5 асуудалд аудитыг чиглүүлэн, аудитын горим

сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

1.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ийн дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь орлогын дүнд тухайн байгууллагын үйл ажилагаанд зарцуулагддаггүй орлого тооцогдох магадлалтай бөгөөд нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгийн дүн бага байгаа тул нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зүйтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Говьсүмбэр аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн үеийн материаллаг байдлын түвшинг үр дүнгийн тайлангийн нийт зардал 156,922.5 мянган төгрөгөөс 1 % буюу 1,569.2 мянган төгрөгөөр тооцсон бөгөөд гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлын түвшинд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэж /ТАБ-СТА-В-1/ маягтаар баталгаажууллаа.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлангийн аудитаар 2 жилд нь “зөрчилгүй”, 1 жилд нь “итгэл” үзүүлсэнтэй холбоотой юм.

Гүйцэтгэлийн явцад шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илрээгүй.

1.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын төлөвлөлтөөр нийт 8 дансанд эрсдэлтэй гэж тооцож, горим, сорил хэрэгжүүлэх явцад 5 дансанд алдаа зөрчил илрээгүй тул нарийвчилсан горим сорил хийгдээгүй бөгөөд зөрчилтэй гэж үзсэн 3 дансанд нарийвчилсэн горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баталгаажуулав. /ТАБ-СТА-В.3.1-В.3.3/, /ТАБ-СТА-В.3.9/

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дахь залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараахь байдлаар ангилав.

(мянган төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	1	0	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	415.0	
3	Албан шаардлага өгсөн	1	25,802.6	
4	Аудитын явцад залруулсан		40,068.0	
5	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
6	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	4	66,285.6	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг /ТАБ-СТА-В-4.3-4.4/ маягтад нэгтгэн баримтжуулав.

1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, ГАРГАСАН ШИЙДЭЛ

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

1. Барилгын засварын материалын данснаас 4,830.0 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулж, 380 квт-ын шугам тавьсан боловч зарцуулалтыг гаргаагүй үлдэгдлээр тайлагнасан зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4, 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Нотлох баримтыг үндэслэн зарцуулалтыг гаргаж, бий болсон хөрөнгийг үнэн зөв бүртгэж, аудитын явцад залруулах

2. 2017 оны санхүүгийн тайлан өглөг, авлагагүй тайлагнагдсан боловч аудитын тулган баталгаажуулалтаар өглөгийн журналд 35,238.0 мянган төгрөгийн нэмэх, хасах үлдэгдэлтэй тайлагнасан зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Баланс тайлангийн үнэн зөв байдлыг хангахын тулд журналын бичилтийг аудитын явцад залруулах

3. Тус байгууллагын НБББББ нь 2009 онд батлагдаж, тухай бүр өөрчлөлт хийгдээгүйгээс одоо ашиглагдаж байгаа санхүүгийн програмын зарим үзүүлэлттэй нийцэхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.9 дэх заалтыг бүрэн хангаж чадахгүй байна.

Шийдвэрлэсэн:НБББББ-т өөрчлөлт оруулах тухай зөвлөмж өгөх

2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

1. Төрийн албан хаагчдад үр дүнгийн урамшуулалаар олгохоор санхүүжүүлсэн 3,900.0 мянган төгрөгнөөс 300.0 мянган төгрөгийг байгууллагын аварга

ажилтныг шагнаж, зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулагдсан 300.0 мянган төгрөгт төлбөрийн акт бичиж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх

2. Хоёр ажилтанд нийт 115.1 мянган төгрөгийн цалинг, ээлжийн амралтын цалинтай давхардуулан олгожээ. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79.1, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Ээлжийн амралт олгох заавар”-ын 13-т заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цалинтай давхардуулан олгосон 115.1 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэх төлбөрийн акт бичих

1.9.1 Албан шаардлага

1. 25,802.6 мянган төгрөгийн тусгай зориулалтын бараа материалыг, сэлбэг хэрэгслэлийн дансанд, дансны ангилал буруу бүртгэжээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.9 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Тусгай зориулалтын бараа материалыг үнэн зөв бүртгэх тухай албан шаардлага өгөхөөр шийлдвэрлэв.

1.9.2 Сахилгын шийтгэл ногдуулахаар алдаа зөрчилтэй асуудал гараагүй.

1.9.3 Хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр алдаа зөрчилтэй асуудал гараагүй.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Говьсүмбэр аймгийн “Ус, цаг уур, орчны шинжилгээний газар”-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 66,285.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 40,068.0 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 415.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 25,802.6 мянган төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлж, НБББББ-ийг шинэчлэн боловсруулах тухай 1 зөвлөмж өглөө.

1.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

1. Анхаарал татсан асуудал байхгүй байна.

1.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Говьсүмбэр аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний газарт өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой хөтөлбөр, арга хэмжээн урсгал зардалд зориулан 136,977.2 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/мянган төгрөгөөр/					
№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	136,977.2	136,906.8	-0,05%	-70,3
1.1	Урсгал зардал	136,977.2	136,906.8	-0,05%	-70,3
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0	0	0.0%	0.0
2	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр				
2.1	Улсын төсвөөс санхүүжих	136,977.2	136,906.8	-0,05%	-70,3
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос				

Говьсүмбэр аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний газар нь 2017 онд 136,977.2 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдсан бөгөөд төсвөө 100 % авч, үйл ажиллагааны зардалд 136,906.8 мянган төгрөгийг зарцуулж, 70.3 мянган төгрөгийн төсвийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлсэн байна. Энэ нь цалин, НДШ, тогтмол зардлаас хэмнэгдсэн байна.

Тайлант онд “Цаг уур, орчны шинжилгээний газар”-аас 878.9 мянган төгрөгийн компьютер, 7,512.7 мянган төгрөгийн багаж, хэрэгслийг үнэ төлбөргүй хүлээн авч, 4,649.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн хорооны шийдвэрээр данснаас хассан бөгөөд авлага, өглөгийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Батлагдсан төсвийг нийт дүнгээр хэтрүүлээгүй боловч 2017 оны 107 тоотойр Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төрийн санд хүсэлт гарган 2,300.0 мянган төгрөгийн зардлыг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна.

Уг байгууллага нь тайлант онд өглөг, авлагын эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны 2017 оны эхний үлдэгдэл 41,945.3 мянган төгрөг байсан бөгөөд тайлант онд төсвийн хөрөнгөөр 8,427.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, ЦУОШГ-аас 7,512.7 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 13,350.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 4,433.6 мянган төгрөгийн бараа материалыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн саналыг үндэслэн байгууллагын даргын тушаалаар 2017 оны А/17 тоот тушаалаар данснаас хасч 40,101.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 190,297.0 мянган төгрөг байсан бөгөөд тайлант хугацаанд 878.9 мянган төгрөгийн хөрөнгийг ЦУОШГ-аас үнэ төлбөргүй

хүлээн авч, 4,649.8 мянган төгрөгийн элэгдлээ 100 % нөхсөн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасч, 186,526.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Тайлант хугацаанд бараа материал болон үндсэн хөрөнгөнөөс актлагдсан нийт 9,083.4 мянган төгрөгийн хөрөнгийг дээрх шийдвэрүүдийн дагуу данснаас хассан боловч хөрөнгийг устгаагүй байна.

Тайлант хугацаанд төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө батлагдаагүй бөгөөд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

1.12 Шилэн дансны мэдээлэл

Говьсүмбэр аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бие даасан цэстэй бөгөөд 20 нэр төрлийн мэдээллийг 149 удаа оруулахаас 2 мэдээлэл хугацаа болоогүй, 12 удаагийн мэдээллийг хоцроож оруулсан ба 91.8 хувийн хэрэгжилттэй байна.

1.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгөгдсөнөөс 1 зөвлөмж нь хэрэгжих боломжгүй гэж үзэж, 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

1.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Говьсүмбэр аймгийн "Ус, цаг уур, орчны шинжилгээний газар"-ын 2017 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэлээ.

Говьсүмбэр аймгийн "Ус, цаг уур, орчны шинжилгээний газар"-ын 2017 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж "Зөрчилгүй" санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Говьсүмбэр аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

Асуудал 1: НБББББ-ийн ТАЛААР

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №01

Илрүүлэлт

Зөвлөмж

Тус байгууллагын НБББББ нь 2009 онд батлагдаж, тухай бүр өөрчлөлт хийгдээгүйгээс одоо ашиглагдаж байгаа санхүүгийн програмын зарим үзүүлэлт нийцэхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.9 дэх заалтыг бүрэн хангаж чадахгүй байна.

НБББББ-т өөрчлөлт оруулах

Эрсдэл

Төсвийн захирагчийн хариу

Нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байдал алдагдах.

Хүлээн зөвшөөрсөн

Асуудал 2: НББ-ийн талаар

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №02

Илрүүлэлт

Өглөг, авлагын журнал болон дансны ангилалыг буруу хөтөлж, ээлжийн амралтын тооцоог тухай бүр хийгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Зөвлөмж

Өглөг, авлага болон дансны ангилалыг үнэн зөв хөтөлж, ээлжийн амралтын тооцоог тухай бүр хийж байх

Эрсдэл

Нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байдал алдагдах.

Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

Асуудал 3: Үндсэн хөрөнгийн талаар

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №03

Илрүүлэлт

Зөвлөмж

Бараа материал, үндсэн хөрөнгөнөөс актлагдсан нийт 9,083.4 мянган төгрөгийн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон байгууллагын даргын шийлдвэрээр данснаас хассан боловч хөрөнгийг устгаагүй байна Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Данснаас хасагдсан 9,083.4 мянган төгрөгийн хөрөнгийг устгаж, акт үйлдэж, баримтжуулах

Эрсдэл

Төсвийн захирагчийн хариу

Нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байдал алдагдах.

Хүлээн зөвшөөрсөн

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Хугацаа: 2017.12.31

SOR T_ID	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	41,945,321.36	40,101,070.06
60	БАРАА МАТЕРИАЛ	41,945,321.36	40,101,070.06
66	Хангамжийн материал	41,945,321.36	40,101,070.06
67	Бичиг хэргийн материал	736,000.00	573,000.00
68	Аж ахуйн материал	11,562,043.04	13,725,436.20
69	Сэлбэг хэрэгсэл	24,447,278.32	25,802,633.86
70	Түлш шатах тослох материал	370,000.00	-
71	Барилгын засварын материал	4,830,000.00	
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	91,406,028.13	81,696,632.22
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	91,406,028.13	81,696,632.22
108	Биет хөрөнгө	91,187,861.32	81,632,465.37
109	Барилга, байгууламж	51,647,174.40	51,647,174.40
110	Хуримтлагдсан элэгдэл	(6,665,174.64)	(7,498,174.68)
111	Авто тээврийн хэрэгсэл	16,333,333.00	16,333,333.00
112	Хуримтлагдсан элэгдэл	(16,333,333.00)	(16,333,333.00)
113	Машин, тоног төхөөрөмж	100,035,870.96	97,550,529.81
114	Хуримтлагдсан элэгдэл	(67,444,680.12)	(72,484,508.80)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,314,929.34	9,029,370.00
116	Хуримтлагдсан элэгдэл	(5,997,072.87)	(5,604,909.57)
122	Бусад үндсэн хөрөнгө	7,595,752.00	7,595,752.00
123	Хуримтлагдсан элэгдэл	(1,898,937.75)	(2,202,767.79)
124	Дуусаагүй барилга, байгууламж	3,600,000.00	3,600,000.00
126	Биет бус хөрөнгө	218,166.81	64,166.85
127	Програм хангамж	770,000.00	770,000.00
128	Хасагдуулга	(551,833.19)	(705,833.15)
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	133,351,349.49	121,797,702.28
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	133,351,349.49	121,797,702.28
215	Засгийн газрын хувь оролцоо	133,351,349.49	121,797,702.28
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	131,875,507.53	131,875,507.53
217	Өмч: -Төрийн өмч	131,875,507.53	131,875,507.53
223	Хуримтлагдсан үр дүн	(3,065,372.33)	(14,619,019.54)
224	Өмнөх үеийн үр дүн	(3,065,372.33)	(3,065,372.33)
225	Тайлант үеийн үр дүн	-	(11,553,647.21)
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,541,214.29	4,541,214.29
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	133,351,349.49	121,797,702.28

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Хугацаа: 2017.12.31

SORT_ID	ITEM_NAME	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	149,459,161.38	145,368,813.12
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,319,061.38	8,391,613.12
77	Нийтлэг татварын бус орлого	1,373,061.38	8,391,613.12
78	Хүүгийн орлого	308,564.00	-
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,064,497.38	8,391,613.12
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,064,497.38	8,391,613.12
95	Хөрөнгийн орлого	6,946,000.00	-
96	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	6,946,000.00	-
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	141,140,100.00	136,977,200.00
112	Улсын төвлөрсөн төсвөөс	141,140,100.00	136,977,200.00
113	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	141,140,100.00	136,977,200.00
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	143,476,601.23	156,922,460.33
148	УРСГАЛ ЗАРДАЛ	143,008,685.23	152,952,118.33
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	143,008,685.23	152,952,118.33
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	104,308,182.00	104,075,111.00
151	Цалин	99,803,682.00	85,026,811.00
152	Нэмэгдэл цалин	-	14,588,800.00
153	Унаа хоолны хөнгөлөлт	4,504,500.00	4,459,500.00
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,600,499.00	11,566,152.00
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	7,370,367.00	7,360,278.00
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	846,026.00	1,051,468.00
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,057,534.00	858,192.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	211,506.00	193,276.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,115,066.00	2,102,938.00
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,812,429.00	3,589,877.00
165	Гэрэл цахилгааны зардал	654,429.00	633,777.00
166	Түлш, халаалтын зардал	2,888,000.00	2,663,000.00
167	Цэвэр, бохир усны зардал	270,000.00	293,100.00

Говьсүмбэр аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын 2017 оны санхүүгийн тайлан

170	Хангамж, бараа материалын зардал	4,216,049.00	6,065,924.84
171	Бичиг хэргийн материал	589,600.00	606,000.00
172	Тээвэр, шатахууны зардал	3,190,000.00	3,500,000.00
173	Шуудан холбоо интернетийн төлбөр	287,449.00	277,678.00
175	Хог хаягдал устгах, цэвэрлэх	96,000.00	96,000.00
176	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	53,000.00	1,586,246.84
181	Нормативт зардал	300,000.00	115,900.00
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00	115,900.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	4,748,324.32	9,358,817.58
186	Багаж хэрэгсэл	4,608,724.32	9,358,817.58
189	Урсгал засвар	139,600.00	-
190	Томилолт, зочны зардал	2,674,000.00	2,922,490.00
192	Дотоод томилолтын зардал	2,674,000.00	2,922,490.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,871,650.00	1,004,650.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,393,000.00	368,500.00
196	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	150,000.00
197	Даатгалын үйлчилгээний төлбөр	99,600.00	106,050.00
198	Тээврийн хэрэгслийн татвар	49,450.00	53,200.00
199	Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,000.00	20,000.00
201	Газрын төлбөр	309,600.00	306,900.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	9,477,551.91	14,253,195.91
210	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,500,000.00
211	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	-	164,900.00
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,477,551.91	10,588,295.91
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	467,916.00	3,970,342.00
228	Бусад урсгал шилжүүлэг	-	3,900,000.00
236	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	3,900,000.00
237	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	467,916.00	70,342.00
240	Төвлөрүүлэх шилжүүлэг	467,916.00	70,342.00
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	5,982,560.15	(11,553,647.21)
288	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	5,982,560.15	(11,553,647.21)

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хугацаа: 2017.12.31

SORT_ID	ITEM_NAME	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	141,140,100.00	136,977,200.00
109	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	141,140,100.00	136,977,200.00
110	Улсын төвлөрсөн төсвөөс	141,140,100.00	136,977,200.00
111	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	141,140,100.00	136,977,200.00
145	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	137,998,572.00	136,977,200.00
146	УРСГАЛ ЗАРДАЛ	137,998,572.00	136,977,200.00
147	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	137,530,656.00	133,006,858.00
148	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	110,858,090.00	104,075,111.00
149	Үндсэн цалин	104,928,090.00	85,026,811.00
150	Нэмэгдэл	1,053,600.00	14,588,800.00
151	Унаа хоолны хөнгөлөлт	4,876,400.00	4,459,500.00
155	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	11,632,868.00	11,566,152.00
156	Тэтгэврийн даатгалын шимтгэл	8,090,372.00	7,360,278.00
157	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	708,499.00	1,051,468.00
158	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	885,625.00	841,174.00
159	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	177,124.00	210,294.00
160	Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,771,248.00	2,102,938.00
162	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	3,812,429.00	3,219,877.00
163	Гэрэл цахилгааны зардал	654,429.00	633,777.00
164	Түлш, халаалтын зардал	2,888,000.00	2,293,000.00
165	Цэвэр, бохир усны зардал	270,000.00	293,100.00
168	Хангамж, бараа материалын зардал	4,288,049.00	4,434,778.00
169	Бичиг хэрэг	582,000.00	443,000.00
170	Тээвэр, шатахуун	3,190,000.00	3,500,000.00
171	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	287,449.00	277,678.00
173	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000.00	96,000.00
174	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	132,600.00	118,100.00
179	Нормативт зардал	250,000.00	253,900.00
182	Нормын хувцас, зөөлөн эдлэл	250,000.00	253,900.00
183	Эд хогшил, урсгал засварын зардал	1,860,000.00	1,865,000.00
184	Багаж техник хэрэгсэл	1,000,000.00	940,000.00
187	Урсгал засвар	860,000.00	925,000.00
188	Томилолт, зочны зардал	2,722,000.00	2,922,490.00
190	Дотоод албан томилолт	2,722,000.00	2,922,490.00
192	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,940,620.00	1,004,650.00
193	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,461,970.00	368,500.00
194	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	150,000.00
195	Даатгалын үйлчилгээ	99,600.00	106,050.00
196	Тээврийн хэрэгслийн татвар	49,450.00	53,200.00

Говьсүмбэр аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын 2017 оны санхүүгийн тайлан

197	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	20,000.00
199	Газрын төлбөр	309,600.00	306,900.00
206	Бараа үйлчилгээний бусад зардал	166,600.00	3,664,900.00
207	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,500,000.00
208	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	166,600.00	164,900.00
219	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	467,916.00	3,970,342.00
223	Бусад урсгал шилжүүлэг	-	3,900,000.00
231	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	3,900,000.00
232	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	467,916.00	70,342.00
235	Төвлөрүүлэх шилжүүлэг	467,916.00	70,342.00
248	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,141,528.00	-
249	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
277	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
300	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	3,141,528.00	-
301	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
302	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,141,528.00	-

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Хугацаа: 2017.12.31

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
0	ДАНС	511	51300	51210+51220	
2	2016 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл				
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
5	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн				
6	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз				
7	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				
8	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/				
9	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл				
10	2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	131,875,507.53	4,541,214.29	(3,065,372.33)	133,351,349.49
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	131,875,507.53	4,541,214.29	(3,065,372.33)	133,351,349.49
13	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн		-		
14	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз		-		
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз		-		
16	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			(11,553,647.21)	(11,553,647.21)
17	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	131,875,507.53	4,541,214.29	(14,619,019.54)	121,797,702.28

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Хугацаа: 2017.12.31

SOR T_ID	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	136,977,200.00	136,906,858.00	70,342.00	99.95
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	136,977,200.00	136,906,858.00	70,342.00	99.95
4	Бараа, үйлчилгээний зардал	133,077,200.00	133,006,858.00	70,342.00	99.95
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	104,087,100.00	104,075,111.00	11,989.00	99.99
6	Үндсэн цалин	85,038,800.00	85,026,811.00	11,989.00	99.99
7	Нэмэгдэл	14,588,800.00	14,588,800.00	-	100.00
8	Унаа, болон бусад нөхөн олговор	4,459,500.00	4,459,500.00	-	100.00
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,585,100.00	11,566,152.00	18,948.00	99.84
12	Тэтгэврийн даатгал	7,372,291.00	7,360,278.00	12,013.00	99.84
13	Тэтгэмжийн даатгал	1,053,327.00	1,051,468.00	1,859.00	99.82
14	ҮОМШӨ ний даатгал	842,442.00	841,174.00	1,268.00	99.85
15	Ажилгүйдлийн даатгал	210,585.00	210,294.00	291.00	99.86
16	Эрүүл мэндийн даатгал	2,106,455.00	2,102,938.00	3,517.00	99.83
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,245,900.00	3,219,877.00	26,023.00	99.20
18	Гэрэл цахилгаан	813,400.00	633,777.00	179,623.00	77.92
19	Түлш, халаалт	1,646,400.00	2,293,000.00	(646,600.00)	139.27
20	Цэвэр, бохир ус	786,100.00	293,100.00	493,000.00	37.29
22	Хангамж, бараа материалын зардал	4,435,700.00	4,434,778.00	922.00	99.98
23	Бичиг хэрэг	446,600.00	443,000.00	3,600.00	99.19
24	Тээвэр (шатахуун)	2,811,000.00	3,500,000.00	(689,000.00)	124.51
25	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	964,000.00	277,678.00	686,322.00	28.80
27	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000.00	96,000.00	-	100.00
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	118,100.00	118,100.00	-	100.00
30	Нормативт зардал	253,900.00	253,900.00	-	100.00
33	Нормын хувцас зөөлөн эдлэл	253,900.00	253,900.00	-	100.00

Говьсүмбэр аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын 2017 оны санхүүгийн тайлан

34	Эд хогшил худалдан авах	1,867,700.00	1,865,000.00	2,700.00	99.86
35	Багаж, техник, хэрэгсэл	1,009,800.00	940,000.00	69,800.00	93.09
38	Урсгал засвар	857,900.00	925,000.00	(67,100.00)	107.82
39	Томилолт, зочны зардал	2,930,700.00	2,922,490.00	8,210.00	99.72
41	Дотоод албан томилолт	2,930,700.00	2,922,490.00	8,210.00	99.72
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,006,200.00	1,004,650.00	1,550.00	99.85
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	368,500.00	368,500.00	-	100.00
45	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	150,000.00	150,000.00	-	100.00
46	Даатгалын үйлчилгээ	107,600.00	106,050.00	1,550.00	98.56
47	Тээврийн хэрэгслийн татвар	53,200.00	53,200.00	-	100.00
48	Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,000.00	20,000.00	-	100.00
50	Газрын төлбөр	306,900.00	306,900.00	-	100.00
53	Бараа үйлчилгээний бусад зардал	3,664,900.00	3,664,900.00	-	100.00
54	Бараа үйлчилгээний бусад зардал	3,500,000.00	3,500,000.00	-	100.00
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	164,900.00	164,900.00	-	100.00
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,900,000.00	3,900,000.00	-	100.00
70	Бусад урсгал шилжүүлэг	3,900,000.00	3,900,000.00	-	100.00
78	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	3,900,000.00	3,900,000.00	-	100.00
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	136,977,200.00	136,906,858.00	70,342.00	99.95
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	136,977,200.00	136,906,858.00	70,342.00	99.95
99	Улсын төсвөөс санхүүжих	136,977,200.00	136,906,858.00	70,342.00	99.95
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	13.00	13.00	-	100.00
134	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
135	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00	-	100.00

